

Монголын нийгмийн сэтгэл зүйн өнөөгийн дүр төрх

Омбоосүрэнгийн Эрдэнэчимэг, доктор (Ph.D), дэд профессор
Шинжлэх Ухааны Академийн Философийн Хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс, erdenechimegomboosuren@gmail.com
<https://orcid.org/0009-0006-1594-5586>

Article history

Received : 2024-08-31
Accepted : 2024-09-23
Published : 2024-12-20

Түлхүүр үгс

нийгмийн сэтгэл зүй, төр, улс төрийн нам, итгэх итгэл, авилга, хээл хахууль

Keywords

social psychology, government, political parties, trust, corruption, bribery

© The Author(s), 2024



Хураангуй: Аливаа нийгэмд болж буй үйл явцыг тухайн нийгмийн ард түмнээс салангид авч үзэх боломжгүй юм. Нийгмийн сэтгэл зүй нь цаг хугацааны өөрчлөлтийн үйл явцад нийгэм хэрхэн хувьсан өөрчлөгдөж байгаагаар уялдан хувь хүн буюу нийгмийн бүлгүүдийн сэтгэл зүйн байдалд гарч буй өөрчлөлт, түүнд үзүүлж буй харилцан нөлөөллийг судалдаг. Тийм учраас өнөөдөр Монголын нийгэмд болж буй улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явцад ард түмэн буюу нийгмийн сэтгэлзүй хэрхэн хандаж байгаа, түүний эерэг, сөрөг өөрчлөлт хэрхэн явагдаж байна, тэр нь улс орны хөгжилд ямар эерэг, сөрөг нөлөөлөл үзүүлж байна зэрэг олон асуудлуудад дүн шинжилгээ хийх зорилгоор энэхүү өгүүллийг тэрлэв. Монгол Улс 1990 оноос нийгмийн байгууллага үндсээр нь өөрчилж ардчилсан тогтолцоонд шилжсэн. Тодруулбал, нэгд, улс төрийн хувьд ардчилсан сонгуультай, олон намын системтэй; хоёрт, эдийн засгийн хувьд чөлөөт өрсөлдөөнтэй зах зээлийн эдийн засагтай, өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрсөн; гуравт, нийгмийн хувьд хүн төвтэй, хүний эрхийг дээдэлсэн хөгжлийн загварыг чухалчилсан тогтолцоонд шилжсэн (Эрдэнэчимэг О. 2022, 100-116). Харин энэ 30 жилийн хугацаанд олсон ололт амжилт, гарсан үр дүн байгаа боловч, зорьсон зорилго, хөгжих ёстой зам, гольдролоосоо хазайсан сорилт бэрхшээл түүнээсээ дутахгүй бий болжээ.

The picture of the present social psychology in Mongolia

Erdenechimeg Omboosuren (Ph.D), associate professor
Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia, erdenechimegomboosuren@gmail.com
<https://orcid.org/0009-0006-1594-5586>

Abstract: It is impossible to separate the processes that occur in any society from the people of that society. Social psychology studies changes in individuals and social groups' psychological states and their mutual effects as society evolves. Consequently, the aim of this paper is to analyze how Mongolian people and social spirits react to the current political, social and economic processes, the positive and negative changes that occur, and the impact that these changes have on the development of the country. Since 1990, Mongolia has fundamentally changed its social structure and has transitioned to a democratic system.

This change includes: 1. Politics: Establishing a democratic electoral system with diverse political parties; 2. Economy: Transitioning to a market economy with free competition and recognizing various forms of ownership; 3. Society: Transitioning to a system that prioritizes human-centered development and upholds human rights. However, important achievements and results have been achieved over the past 30 years, but challenges and deviations have also occurred in the development of the goals and development pathways planned.

I. Оршил

1990 онд Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээр ардчилсан Үндсэн хуультай болж түүнд зохицсон эрх зүйн шинэтгэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэн, төрийн институцүүд төлөвшиж улс төрийн тогтолцоо бүхэлдээ ардчилсан шинж төрхтэй болсон.

Хэдийгээр Монгол Улс ардчиллыг амжилттай хэрэгжүүлж байгаа ч улс төрийн системийн тогтворгүй байдал, эрх мэдлийн институцүүдийн харилцан тэнцвэртэй байх механизм алдагдсан, нийгэмд шударга бус байдал үүссэн, албан тушаалын эх үүсвэртэй авилгал, хээл хахууль газар авч, орлогын тэгш бус байдал бий болсон зэрэг нь бидний хүсээгүй үр дүн. Мөн ялсан улс төрийн хүчин бүхнийг гартаа авдаг асуудал бол улс төрийн сонгуулийн тогтолцооны сөрөг үр дагавар юм. Өнөөдөр аль ч улс төрийн намын дотоод ардчилал үгүй болсон. Өөрөөр хэлбэл намын улс төрийн шийдвэрийг эрх мэдэлд ойр цөөнх гаргадаг механизм бий болгосон нь улс төрийн нам институцийн зарчмаар ажиллах эрхээ алдаж, улс төр, бизнесийн бүлэглэлд боломж олгож, ардчиллын элементүүдийг бүдгэрүүлж, олигархуудыг төрүүлэх хөрс суурийг бий болгосон нь нэг том алдаа бөгөөд, энэ нь иргэдийн болон намын жирийн гишүүд дэмжигчдийн дургүйцлийг хүргэхэд дээд зэргээр нөлөөлсөн аж.

Өнөөдөр Монгол Улсад хяналт, хариуцлагын систем бүрэн алдагдсан. Хяналт, хариуцлага бол сайн засаглалын салшгүй нэгэн бүрдэл хэсгүүд билээ. Хуулийн хэрэгжилт дагасан тодорхой хяналт, хариуцлагын механизмгүйгээр нийгэм, эдийн засгийн үр нөлөөтэй хөгжил, авилгал, хээл хахуулиас ангижрах тухай ярих нь илүүц. Тиймээс бүх шатанд хяналт хариуцлагын тогтолцоог иж бүрэн төлөвшүүлэх шаардлага гарч байна. Хяналт, хариуцлага сул байгаагаас үүдэн төрийн өмчийг элдэв арга саам хийж эзэнгүйдүүлэх, хуйвалдах, идэж шамшигдуулах, авилгад идэгдэх, хуулийг үл хайхрах, ёс зүйгүй авирлах, хариуцлага хүлээхгүй байх зэрэг зохисгүй үйлдлүүд газар авсаар байна. Үүнд: ЖДҮ, Хөгжлийн банк, Нүүрсний хулгай, Тариалан эрхлэлтийн болон Боловсролын зээлийн сан гэх мэт олон жишээ баримтыг дурьдаж болох юм.

Энэ бүхэн нь улс орны эдийн засгийн хөгжил, хүн ардын амьжиргаанаас хойш татахын хажуугаар төрийн дархлааг сулруулж төрд итгэх иргэдийн итгэлийг улам бууруулж тэдний дургүйцэл, үзэн ядалтыг төрүүлж байна.

II. Судалгааны арга зүй

Монголын нийгмийн улс төр, нийгэм, эдийн засгийн байдлыг олон түмэн хэрхэн үнэлж байна, ямар тулгамдсан асуудал байна гэдгийг тандан судалж үнэлэлт дүгнэлт өгөх

зорилготой. Судалгааг 2024 оны 2 дугаар сард хийсэн чанарын судалгаа, мөн 2023 оны 4 дүгээр сард 400 респондентуудыг хамруулан хийсэн тоон судалгааны үр дүн, дүгнэлт шинжилгээнд үндэслэсэн болно.


Ш. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

Хүснэгт 1. Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн байдлын талаарх олон түмний санаа бодол /2000-2024 онууд

№		2001	2002. 2 сар	2004. 3 сар	2006. 3 сар	2014. 4 сар	2017. 10 сар	2021. 4 сар	2023. 4 сар	2024. 2 сар
1	Тааламжтай, хэвийн	35.5	37.2	34.9	31.6	20.3	15.2	13.1	13.0	19.7
2	Дунд зэрэг	18.4	28.9	34.9	40.5	24.6	13.5	4.9	2.4	
3	Хямралтай аюултай	6.5	16.4	24.0	18.3	34.1	71.3	82.0	84.7	80.3
4	Хариулж мэдэхгүй	9.0	17.5	6.3	6.6	20.2				

Эх сурвалж: Сантмарал, Прогноз, Магадлал төвийн судалгаануудын тоон үзүүлэлтүүд

Зураг 1. Улс орны нөхцөл байдлын талаарх олон түмний санаа бодлын динамик өөрчлөлт



Улс орныхоо улс төр, нийгэм, эдийн засгийн байдлыг “тааламжтай, хэвийн” гэсэн үзүүлэлт 2014 оноос эрс буусан, “хямралтай, аюултай” гэсэн үзүүлэлт 2014 оноос эрчимтэй өссөн дүн харагдаж байгаа ба өнөөдөр энэ үзүүлэлт 80.3%-д хүрсэн байна.

Энэ бол нийгмийн сэтгэл зүйн хувьд **онцгой анхаарах** үзүүлэлт мөн. Нийгмийн сэтгэл зүй ийм хэмжээнд хүртэл 10-аад жил үргэлжилж өнөөдөр бараг хамгийн доод хэмжээнд хүрчээ. Үүнд: Иргэдийн амьдралын түвшний доройтол, өргөн хэрэглээний барааны

өсөлт, ажлын байрны хомсдол, дээр нь байгалийн баялгийн тэгш бус хуваарилалт, албан тушаалтнуудын авлигийн хэргүүд, түүнд олноороо хамрагдаж байгаа дуулианууд нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж байна.

Ингээд Монголын нийгэмд бий болсон хямралын учир шалтгааны талаар онолын болон прагматик талаас нь судалж, өнөөгийн нөхцөл байдлаа зөв оношлох шаардлагатай байна. Улс төрийн шинжлэх ухааны үүднээс бол өнөөдөр Монголын төр түүний үйл ажиллагааны хүрээнд хямралын зарим шинжүүд бүрэлдэн бий болжээ гэж үзэх үндэстэй байна. Өөрөөр хэлбэл улс төрийн хүрээний хямрал, түүнд хүргэж болох гажуудлууд нь улс төрийн институт, тэдгээрийн үйл ажиллагаа, **улс төрч лидерүүдийн төлөвшил, тэдгээрийн ёс зүй, хариуцлага, улс төрийн үзэгдлийг зохицуулах эрх зүйн зохицуулалтын хүрээнд тодорхой илэрч байна.** Энэ үйл явцууд нь цаг үеийн тодорхой нөхцөл байдал, түүнээс үүссэн асуудлуудын өвөрмөц онцлогтой уялдан зарим үед намжиж, зарим үед дахин сэдэрч ил болж явсаар багагүй хугацаа өнгөрлөө. Монголын улс төрийн хямрал гол төлөв улс төрийн нам, улс төрчдийн төлөвшил, тэдний хувийн шинжтэй тоглолтуудтай холбоотой байдгаараа онцлог юм.

Ингээд улс төрийн, эдийн засгийн, нийгмийн хямралын үндсэн шалтгаан юу байдаг талаар товч өгүүлье. Нэгдүгээрт: Улс төрийн хямралын үндсэн шалтгаанд:

1. *Ард түмний амьдралын түвшинд гарсан өөрчлөлтөөр үүсэх улс төрийн тогтолцооны гадаад орчны*

таагүй байдал,

2. *Улс төрийн тогтолцооны бүрдэл хэсгүүд дэх хуучин байсан болон шинээр үүсэн бий болж буй зөрчлийг улам хурцатгаж байдаг орчны болон дотоод эмх цэцг, замбараагүй байдал,*
3. *Тухайн системийн удирдлагын гажуудал зэргийг нэрлэж болно.*

Жич: Эндээс харахад хямралын үндсэн шалтгаан болох ард түмний амьдралын түвшинд гарсан өөрчлөлтөөр үүсэх улс төрийн тогтолцооны гадаад орчны таагүй байдал манайд хэдийн бий болсон. Учир нь олон учир шалтгааны улмаас ард түмний амьдрал сайжрахгүй, нийгмийн доод хэсэг буюу ядуусын тоо жилээс жилд өсөж байгаа. Үүнтэй зэрэгцээд Монголын нийгэмд хяналтын систем ажилладаггүй, төрийн өндөр дээд түвшинд ажиллагсдын хариуцлага, сахилга бат улам суларсан, эрх ашгийн эрэмбэ алдагдсан зэрэг сөрөг асуудлууд газар авсан.

Улс төр, нийгмийн хямралд нөлөөлж буй хүчин зүйлүүдэд: Эрх мэдэл болон засаглалын бүрэн эрхээ буруугаар хэтрүүлэн ашиглах, эдийн засгийн тогтвортой бус байдал, ядуурал, амьжиргааны түвшний бууралт зэрэг шалтгаанууд нөлөөлж байгааг анхаарч, цаашид авах бодлого, арга хэмжээнүүдэд тусгах шаардлагатай гэж үзэж байна.

1990-ээд оны эхээр бидэнд ардчиллын бэлэн туршлага, уламжлал байгаагүй, зөвхөн өөрийн орны нөхцөл байдалд нийцүүлэн тулгамдсан асуудлыг гал унтраах маягаар шийдвэрлэж ирсэн. Энэ үеэс нийгмийн

харилцааны чухал чиглэлүүдэд алдаж оносон, ор тас орхигдуулсан асуудлууд хуримтлагдсаар өнөөдрийг хүрсэн. Тэр асуудлууд өнөөгийн Монгол Улсын нийгэм, улс төрийн амьдралын хүрээнд бий болсон гажуудлын урьдчилсан нөхцөл, суурь нь болсон гэж үзэх үндэстэй. Германы нэрт социологич Э.Дюркгеймийн «Шинэ нийгэмд ишлжих зан суртахууны үндсийг бий болгоогүй нөхцөлд эдийн засгийн, улс төрийн хамгийн зөв шийдвэр ч бүрэн хэрэгжиж чадахгүй» гэсэн онолын ойлголт бидний өнөөгийн нийгэмд бий болсон хямралт байдлаар нотлогддог.

Харин монголын улс төрийн тогтолцооны чухал хэсэг болох улс төрийн институцэд иргэд, олон нийтийн итгэл ямар байгааг судлан

үзэж, дүгнэлт хийхэд дараах нөхцөл байдал ажиглагдсан болно.

Төр засгийн байгууллагууд болон улс төрийн институцүүдэд итгэх итгэлийн судалгаануудыг улс төр судлалын хүрээнд олон судалгааны байгууллага, судлаачид байнга хийж ОНСБ-ын үндсэн дээр институцийн талаарх үнэлгээ, дүгнэлт, харьцуулалт хийгддэг. Өөрөөр хэлбэл төрийн институциудын бодлого үйл ажиллагаа, үр дүнг ард түмэн хэрхэн хүлээн авч байна, тэдний аж амьдралд эерэг, сөрөг нөлөөллийн аль нь илүү нөлөөтэй байна гэх мэт олон асуудлуудыг судалж үнэлэлт, дүгнэлт өгдөг. Эдгээр нь ирээдүйн сонгуулиудын үр дүнд нөлөөлдөг хүчин зүйл болж байдгаараа онцлог.

Хүснэгт 2. Иргэдийн улс төрийн институцүүдэд итгэх итгэл


д/д	Институцүүд	2003 он	2005 он	2010 он	2014 он	2017 он. 3 сар	2018 он	2019 он	2020 он	2021 он. 4 сар	2022 он. 5 сар	2023 он	2024 он. 5 сар
1	Ерөнхийлөгч		52.3	41.6	60.4	41.8	74.9	72.1	83.3	70.8	65.6	45.8	52.1
2	УИХ	59.2	52.6	28.1	39.6	51.4	33.3	36.1	50.3	47.5	49.0	32.1	35.7
3	Засгийн газар	58.3	54.3	31.0	44.2	46.3	35.1	50.8	75.3	57.2	51	33.3	50.1
4	Улс төрийн намууд	49	50.5	14.9	27.1	33.3	22.7	23.8	35.1	30.4	33.6	26.6	32.1

Эх сурвалж: 2000-2024 оны хоорондох судалгааны мэдээллүүд: Прогноз хүрээлэн, Сантмарал сан, УТБА-ийн Азийн барометр судалгааны мэдээллэд үндэслэв.

Дээрх судалгаануудын динамик өөрчлөлтүүдээс харахад Монголын нийгмийн улс төрийн харилцаанд ордог улс төрийн институцүүдэд ард түмний итгэх итгэл харьцангуй өөр өөр үнэлгээтэй байна. Эдгээрээс хамгийн муу үнэлгээтэй буюу олон түмний итгэлийг хамгийн их алдсан институцээр улс төрийн намууд тодорч байна. 2000 оны эхээр иргэдийн улс төрийн намд итгэх итгэл өндөр байсан. (Тухайн үед хийж байсан олон

судалгааны дундаж ойролцоогоор 47.0-52.0% орчимд хэлбэлзэж байсан). Дээрх судалгааны дүнгээс харахад 2010 оны үеэс намуудын рейтинг эрс доошилсон дүр зураг харагдаж байна. Улс төрийн нам, институци, лидерүүдэд итгэх итгэл буурсаар байгаа нь нийгмийн идэвх оролцоо, улс төрийн тогтвортой байдал, ардчиллын хөгжилд сөрөг нөлөөлөх магадлалтай гэж энэ чиглэлийн эрдэмтэн судлаачид үздэг.

Зураг 2. Иргэдийн улс төрийн институцүүдэд /УИХ ба Улс төрийн намуудын хувьд/ итгэх итгэлийн динамик өөрчлөлт



Улс төрийн намуудын рейтинг буусантай зэрэгцээд УИХ-ын нэр хүнд, түүнд итгэх олон түмний итгэл бас бууралттай байна. Яагаад ийм байдалд хүрэв, яагаад олон түмний дургүйцэл, эгдүүцэл ихсэж байна гэдэгт дүн шинжилгээ хийх шаардлага тулгарч байна.

Үүнд хамгийн их сөрөг нөлөө үзүүлж буй шалтгаанд: Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд сонгуульд оролцож, төр барьсан улс төрийн намуудын биелэгдээгүй амлалтууд; улс төрийн намын нэрээр сонгогдож томилогдсон хүмүүсийн эрх ашгийн эрэмбэ алдагдсан, өөрөөр хэлбэл улс орны эрх ашиг гэхээсээ илүү амин хувийн ашиг хонжоо харж улсын хөрөнгө идэж шамшигдуулан, ард түмний нүдэн дээр санхүүгийн чөлөөт байдалд шилжиж, дураараа авирлаж, хуулийн хариуцлага хүлээхгүй байгаад ард түмэн дургүйцэж байна.

Монгол Улс шинэ Үндсэн хууль баталж Парламентын засаглалд шилжсэнээс хойш 30 гаруй жил болж байгаа хэдий ч хууль тогтоох институцийн ард түмнийг төлөөлөх үүрэг сонгуулиас сонгуулийн хооронд

багсч, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх үүрэг функц саарч, улмаар хууль тогтоох дээд байгууллагад олон түмний итгэх итгэл улам муудаж байгаа нь дээрх судалгааны дүнгээс харагдаж байна.

Монголын улс төрийн системд чухал байр суурь эзэлдэг улс төрийн нам яагаад олон түмний дунд нэр хүнд нь унаж, олны итгэл алдрал гэсэн асуулттай бид тулгарч байна.

Энэ асуултанд хариулахын өмнө 2012 онд Философийн хүрээлэнгийн Улс төр судлалын салбараас гүйцэтгэсэн “Нийслэлийн сонгогчийн дүр төрх” судалгааны дүнгээс хэсэгчлэн танилцуулья. Уг судалгаанд оролцогсдын 81.0% нь сонгуулиас ямар нэг байдлаар залхсан дүр зураг харагдаж байна. Яагаад сонгуулиас залхсан шалтгааныг тодруулахад: *сонгууль шударга бус болдог (64.5%), сонгууль хоосон амлалт, хууран мэхлэлт болдог (54%), шударга бус улс төрчдийн балаг (39.6%), мөнгөний сонгууль болдог (28.3%), сонгууль нь ажил, цаг үрсэн, олон түмэнд өгөөжгүй (22.9%), итгэл хүлээсэн улс төрч гарч ирдэггүй (20.6%),*

сонгуульд нэр дэвшигчдийн тэнцвэргүй өрсөлдөөн, бохир технологи (12.0%) зэрэг олон сөрөг асуудлуудтай холбон үзжээ.

Дээрх судалгааны дүн, мөн бидний хийсэн судалгааны дүнгүүдээс харж дүгнэлт хийвэл, улс төрийн намд итгэхгүй болсон үндсэн гол шалтгаан нь:

а) Монголын нийгэмд шударга ёс алдагдсан, төрд өндөр алба хашиж буй эрхмүүд /намаас сонгогдож, томилогдсон албан тушаалтнууд/ авилга, хээл хахуулийн хэрэгт холбогддог хирнээ хууль хэрэгжүүлдэггүй хоёр стандарт бий болсон, төсвийн мөнгө санхүүгээс дур зоргоороо идэж шамшигдуулдаг, албан тушаалыг танил тал, мөнгөөр шийддэг, амин хувийн эрх ашиг, эрх ямбыг тэргүүн зэрэгт тавьдаг зэрэг олон асуудлуудаас үүдэлтэй.

б) Намын бодлого үйл ажиллагааг нийтийн эрх ашигт биш зөвхөн өөрсдийн хүрээллийн явцуу эрх ашигт нийцүүлдэг, өөрөөр хэлбэл гишүүд дэмжигчдийнхээ санал, дэмжлэгт тулгуурлан тэдний оролцоог хангах замаар биш, зөвхөн улс төр, бизнесийн төлөөллийн зарчмаар ажиллаж ирсэн учир улс орны хэмжээний томоохон бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажил саармагжиж зөвхөн ашиг сонирхлын зарчимд шилжсэн.

в) Улс төрийн намуудын бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх үйл явц нь ил тод, төлөөллийн ардчиллын зарчмаар биш явагддаг. Өөрөөр хэлбэл намын бүх шатны байгууллагад дотоод ардчилал үгүй болж, ил тод байдал алдагдаж өрсөлдөөнгүй болсон. Гишүүдийн оролцоог ихэнх

тохиолдолд худалдаж авдаг болсон зэрэг нь олигархуудыг мөнгөөр төрүүлэх таатай орчныг бий болгосон. Ингэж УИХ-д мөнгөний болон улс төр, бизнесийн бүлэглэл хүчтэй орж ирсэн.

г) Төрийн алба улс төрөөс хэт хараат болж сонгуулийн циклээр намын удирдлагад ойр хэсэг өөрсдийн ойрын хүнийг буюу мэдлэг боловсролоор дүлхан, хүмүүжил, ёс суртахууны доголдолтой, бэлтгэгдээгүй, ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдлын хүмүүсийг ихэнхдээ томилж олон түмний дургүйцлийг хүргэдэг зэрэг шалтгаануудыг дурьдаж болно.

Үнэн хэрэгтээ өнөөдөр улс оронд бий болсон хямралт байдал, төрд, намд итгэх олон түмний итгэл буурсан шалтгаан нь улс төрийн намуудын удирдлагад гарсан цөөхөн хэдэн хүн улс төр, бизнесийн бүлэглэл, олигархийг бий болгож, тэдний ашиг сонирхолд хөтлөгдсөнөөс үүдэлтэй. Тийм учраас улс төр, бизнесийн заагийг тогтоож, харилцан хамаарлыг хязгаарлах хууль эрх зүйн орчныг бий болгох явдал нэн чухал байна гэж үзэж байна.

Манай улсад Ардчилсан засаглалын дараах шинжүүд хир төлөвшиж байгаа талаар иргэдээс 1-5 баллын үнэлгээгээр үнэлүүлэхэд: (Эрдэнэчимэг О. 2024):

Ардчилсан засаглалын үнэлгээнүүд нь ерөнхийдөө их доогуур үнэлгээтэй гарсан нь ардчилал ихээхэн сул хөгжиж байгаагийн нэг илрэл бөгөөд харин эрэмбэ дараалал нь өнөөгийн манай улсын улс төр, нийгмийн амьдралын бодит байдалтай нийцсэн, тун дүйхүйц үр дүн гарчээ. Тухайлбал: хариуцлага

хүлээх байдал – 1.34; шударга ёс – 1.63; хариуцан тайлагнах байдал – 1.75; хуулийн хэрэгжилт – 1.94; иргэдээ сонсож, төрийн үйлчилгээ үзүүлэх

– 2.06; иргэдийн оролцоо – 2.09; нээлттэй ил тод байдал – 2.11 баллын үнэлгээтэй гарсан байна.

Зураг 3. Ардчилсан засаглалын зарим шинжүүдийн үнэлсэн байдал (1-5 баллын үнэлгээгээр)




Хамгийн өндөр үнэлгээг “Нээлттэй ил тод байдал” – 2.11 гэж үнэлсэн байгаа ба хууль бус үйлдлүүд болох хөгжлийн банкны, нүүрсний, эмийн гэх мэт авлига, хээл хахууль, албан тушаалын хэргүүдийг ил болгож, нийтийн сонсгол хийсэн явдал нь үүний тод илрэл гэж ойлгож болох юм.

Харин монголын хөгжлийн хандлага ямар чиглэлд явж байгааг 1-2 хүртэлх сонголттой асуултад дараах хариултаудыг буюу ардчилал нэрийн дор сахилга бат, хариуцлага алдагдсан, авилгал хээл хахуульд идэгдсэн, байгалийн баялагийн хуваарилалт тэгш бус, шударга бус

нийгэм рүү гулсаж байна (54.4%); жирийн иргэд олон түмэнд ээлтэй биш хандлагатай нийгэмд амьдарч байна (36.7%); өнөөдрийн нийгэмд бүхэлдээ оюун санаа, хүмүүжил, ёс суртахуун, удирдлага зохион байгуулалтын задралын процесс хүчтэй явагдаж байна (26%); хөгжлийн чиг хандлага ойлгомжгүй зогсонги байдалд байна (24.3%); шилжилтийн үеэс гарч чадахгүй мунгинаж байна (12.4%); ерөнхийдөө урагшаа тэмүүлж чиглэсэн зөв хандлагаар явж байна (7.7%) хэмээн тус тус хариулсан бол хөгжлийн зөв замыг сонгож чадсан гэдэгт судалгаанд оролцогчид огт хариулаагүй байна.

Зураг 4. Монголын хөгжлийн хандлага ерөнхийдөө ямар чиглэлд явж байна



Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогсдын талаас илүү хувь нь буюу 2 хүн тутмын нэг нь «Ардчилал нэрийн дор сахилга бат, хариуцлага алдагдсан, авилгал хээл хахуульд идэгдсэн, байгалийн баялагийн хуваарилалт тэгш бус, шударга бус нийгэм рүү гүлсаж байна» гэсэн аж. Энэ бол өнөөдрийн манай улс оронд өрнөж буй үйл явдлуудад иргэд тааламжтай биш, хөгжлийн чиг баримжаанд эргэлзсэн байдал илэрхий байна. Хамгийн чухал нь хяналт хариуцлагын тогтолцоо, шударга ёс алдагдсанд үндсэн алдаа

завхрал оршиж байгааг илэрхийлсэн байна.


Энэ дүнгээс харахад нийгмийн байгуулал өөрчлөгдсөн үеэс өнөөг хүртэл 34 жил өнгөрчээ. Энэ хооронд улс орны хөгжлийн бодлого, зорилтын хэрэгжилт гажууджээ гэж хэлж болохоор байна.

1990 оноос хойш өнөөг хүртэлх хугацаанд аль үед нь манай улс орны ерөнхий байдал хамгийн тааламжтай байсан ба Таны амьжиргаа хамгийн сайн байсан зэрэгт дараах байдлаар хариулжээ

Хүснэгт 3. Иргэдийн улс төрийн институцүүдэд итгэх итгэл (Эрдэнэчимэг О. 2023, 32)

№	он	Хөгжлийн тааламжтай үе	Таны амьжиргаа сайн байсан үе
1	1992-1996 он	8.3	6.9
2	1996-2000 он	9.0	6.3
3	2000-2004 он	15.2	8.1
4	2004-2008 он	20.7	17.5
5	2008-2012 он	38.6	36.3
6	2012-2016 он	20.7	21.9
7	2016-2020 он	6.2	20.6
8	2020-2023 он	6.9	11.3

Зураг 5. Улс орны хөгжлийн тааламжтай үе ба хувь хүний амьжиргаа сайн байсан үе



Судалгаанд оролцогсдын 38.6% нь 2008-2012 оныг улс орны хөгжилд хамгийн тааламжтай үе байсан гэж үзжээ. Яагаад энэ үеийг сонгох болсон шалтгааныг судлан үзвээс:

2009 онд Оюутолгойн гэрээг үзэглэсэн, уул уурхайн орлого хурдацтай нэмэгдсэн, гадаадын хөрөнгө оруулалт дээд цэгтээ хүртэл өссөн зэрэг олон үйл явдал давхацсан үе байсан ажээ. Тухайлбал: ДНБ-ний өсөлт 2010 онд 6.4% байсан бол 2011 онд 17.3% болж түүхэнд байгаагүй өндөр үзүүлэлтэнд хүрсэн (World Bank, 2023). 2010 онд ажилгүйдлийн түвшин 13.0% байсан бол 2011 онд 9.0% болтол буурсан байна.

Мөн мөнгөний бодлогын тухайд Монгол банкаас инфляцийг хязгаарлах, зээлийн өсөлтийг хумих чиглэлээр 2011 онд маш чухал арга хэмжээнүүдийг авч ажилласан ажээ. Тухайн үед экспортын гүйцэтгэл 2010 оны эцэст 2.9 тэрбум ам.доллар байсан бол 2011 онд 4.8 тэрбум ам.доллар болж өссөн ба экспортын гол бараа бүтээгдэхүүн нь БНХАУ руу гаргаж байсан нүүрс байсан. Энэ үед гадаадын шууд хөрөнгө оруулалт 5.3 тэрбум ам.доллар хүрч, ДНБ-ний 62

орчим хувьтай тэнцэж байсан ажээ.

Дээрх Монгол Улсын эдийн засагт гарч байсан эерэг үзүүлэлтүүд ард түмний амьдралд сайнаар нөлөөлж тус дэм болж байсныг 10 гаруй жилийн дараа иргэд сонгогчид маань санах ойдоо хадгалсан хэвээр байна. Өөрөөр хэлбэл улс орны хөгжлийн хамгийн тааламжтай үед өөрийн амьжиргаагаа хамгийн сайн байсан үе гэж бас дүгнэсэн байна. Дээрх үзүүлэлтээс харахад иргэд өөрийн амьжиргаа, санхүүгийн байдалтай уялдуулан улс орныхоо ерөнхий байдлыг үнэлж дүгнэж байгаа нь харагдаж байна.

Тухайн үеийг хэн хамгийн тааламжтай гэж үзсэнийг тодруулбал:

- *Насны байдлаар*: 35-44 насныхан – 45.8%, 65-аас дээш насныхан 40%
- *Боловсролын байдлаар*: докторууд – 44.4%, тусгай дунд боловсролтой иргэд – 50%
- *Орлогын түвшингээр*: Хэвийн амьдралтай иргэдийн – 55%, чинээлэг амьдралтай иргэдийн 53.6%
- *Эрхэлж буй ажлаар*: худалдаа үйлчилгээний салбарт ажиллагсдын 71.4%, хувийн хэвшилд ажиллагсдын 40.5%, тэтгэвэрийнхэний 44.4%

- *Гишүүнчлэлээр нь авч үзвэл:* нам бусчууд – 45.8%
- *Амьдралын нөхцөлөөр нь:* нийтийн байранд амьдрагсад – 100%, хашаа байшинд амьдрагсад - 100% тус тус тааламжтай байсан гэж үзжээ.

Улс орны өмнө тулгамдаж буй асуудлуудын нэгд, Үндэсний баялаг бүтээх, өөрөөр хэлбэл дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал; *хоёрт*, Авлига, хээл хахууль, улс төр, эдийн засагтай сүлбэлдсэн тогтолцоотой тэмцэх, хяналт хариуцлагын систем бий болгох; гуравт, Иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн ажлын байр нэмэгдүүлэх, цалин тэтгэвэр нэмэх, өргөн хэрэглээний барааны үнийн

өсөлтийг хязгаарлах зэрэг асуудлууд оржээ. Энд нэг зүйлийг тодруулан хэлэхэд урьд өмнө хийж байсан судалгаануудад (2000-2013) хамгийн тулгамдсан асуудалд ажилгүйдэл, ядуурал, үнийн өсөлт, татварын дарамт гэх мэт иргэдийн амьжиргаагаар холбоотой асуудлууд орж ирдэг байсан бол өнөөдөр Үндэсний үйлдвэрлэл хөгжүүлэх, авилгал хээл хахуультай тэмцэх зэрэг асуудлууд хамгийн тулгамдсан асуудал болж орж ирж байгааг нэн түрүүнд анхаарч арга хэмжээ авах асуудал мөн болохыг доорх хүснэгтээс дэлгэрэнгүй харж болохоор байна.

Хүснэгт 4. Улс орны өмнө хамгийн их тулгамдсан чухал асуудал (Эрдэнэчимэг О. 2023, 32)

№	тулгамдаж буй асуудал	хувь	№	тулгамдаж буй асуудал	хувь
1	Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	39.9	7	Төр засгийн байгууллагуудын хариуцлагын тогтолцоог сайжруулах	17.9
2	Авлига, хээл хахуультай тэмцэх	34.5	8	Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг хязгаарлах	13.7
3	Ажлын байр нэмэгдүүлж ажилгүйдлийг ажилтай болгох	26.8	9	Байгалийн баялгийн тэгш бус хуваарилалтыг арилгах	13.1
4	Татварын дарамтыг багасгах	22.0	10	Иргэдийн ёс суртахуун, соёлыг дээшлүүлэх	12.5
5	Улс төр, эдийн засгийн бүлэглэлтэй бүх аргаар тэмцэх	21.4	11	Хүүхэд, залуучуудын хүмүүжил, ёс суртахуун, боловсролын чанарт анхаарах	11.3
6	Цалин, тэтгэвэр нэмэх	18.5			

Судалгаанд оролцогсдын 34.5% нь нийгмийн хамгийн тулгамдсан асуудал бол авлига, хээл хахуультай тэмцэх асуудал гэжээ. Өнөөдрийн Монголын нийгмийн хамгийн дуулиан шуугиантай асуудал бол яах аргагүй авилгал, албан тушаалын хэргүүд юм.

Олон улсын Трансперенси интернэйшнл судалгааны

байгууллагын дүнгээс үзэхэд Монгол Улсын хувьд сүүлийн 13 жилийн хугацаанд үнэлэгдсэн авилгын төсөөллийн индекс дунджаар 38-40 оноогоор үнэлэгдэж, улмаар дэлхийн улс орнуудын 111-115 дугаар байрт эрэмблэгдэж байна (Transparency International. 2023). Энэ нь тус судалгаанд оролцсон улс орнуудын

гуравны хоёр нь 50-иас бага оноо авсан бөгөөд дунджаар манай улсын авч буй 43 гэсэн оноо нь “илүү их авилгалд автсан” гэсэн утгыг илэрхийлж байна.

Мөн АТГ-ын «Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авилгын талаарх төсөөллийн судалгаа»-ны үр дүнд шинжилгээ хийж үзэхэд шинжээчдийн 80-аас дээш хувь нь Монгол Улсад авлига түгээмэл буюу тархалт өндөр, далд хэлбэртэй байна гэжээ (Хатанболд О, Ганцоож Б. 2023, 60-80). Энэ бүгдээс харахад нийгмийн сэтгэл зүй авилгал, хээл хахууль, албан тушаалын гэмт хэргүүдэд маш их дургүйцэлтэй байгаа

нь харагдаж байна. Тиймээс авилгатай хийх тэмцлийг улам эрчимжүүлж, хууль дүрмийг сайжруулж, хүлээх хариуцлагыг чангатгаж хуулийн гадуурх үйлдлүүдэд 2 стандарт гаргалгүй хүн бүрт зохих хариуцлага хүлээлгэж байх шаардлага байна. Ингэж ажиллалбал улс орон авилгын савраас ангижрах бүрэн боломж бүрдэнэ гэж итгэж байна.

Өнөөдрийн Монголын нийгэмд олон түмний дэмжлэг авах хамгийн сайшаалтай ямар ажил, үйл хэрэг байна вэ? (Эрдэнэчимэг О. 2024, 33) гэсэн нээлттэй асуултанд хариулсан байдлыг кодлон авч үзвэл:

Зураг 6. Сайшаалтай ажил үйлс



Хамгийн сайшаалтай ажилд “Авилгатай тэмцэж буй 5Ш ажиллагаа”, нээлттэй сонсголуудыг гэж үзсэн байна. Харин олон түмний дургүйцлийг хамгийн их хүргэж буй асуудалд: гэсэн нээлттэй асуултыг цаасаар болон ярилцлагын хэлбэрээр 2 янзаар тавьж хариултыг үзэхэд хоорондоо дүйж байгаа үр дүн харагдаж байна (Эрдэнэчимэг О.,

Улаанбаатар хотод хийсэн захиалгат чанарын судалгааны тайлан 2024, 33).

Олон нийтийн дургүйцлийг хамгийн их хүргэж буй асуудалд Авилгал, хээл хахууль, буруу шийдвэрүүд, замын түгжрэл, төрийн албан хаагчдын ёс зүй, агаарын бохирдол орсон байна. Доорх зурагт харуулсанчлан “Хамгийн сайшаалтай ажил”, “Хамгийн их дургүйцэл

хүргэж байгаа ажил”-д сайшаасан нь: авилгал, хээл хахуультай тэмцэж байгааг, дургүйцэл төрүүлж байгаа нь авилгал, хээл хахууль гэсэн байна. Үүнээс харахад иргэд, олон түмний дургүйцлийг хамгийн их төрүүлж

байгаа асуудал бол авилгал, хээл хахуулийн асуудал болж байна. Тийм учраас авилгал, хээл хахуультай тэмцэх ажлыг төрийн байгууллагууд, улс төрийн намууд чухалчлан үзэж ажиллах шаардлагатай байна.

Зураг 7. Иргэдийг дургүйцлийг хамгийн их хүргэж буй асуудлууд



Иргэд мэдээллийн эх үүсвэрүүдийг хэрхэн ашигладаг талаар тандан судлахад, иргэдийн хувьд хамгийн гол эх сурвалж болгон ашигладаг өнөгийн нийтлэг зүйл нь фейсбүүк (Facebook) болсон байна. Судалгаанд оролцогсдын 74.2% нь фейсбүүк (Facebook) байнга ашигладаг, 43.9%

нь телевиз байнга үздэг, харин 40.9% нь хааяа үздэг, Интернет сайтуудыг 27.3% нь байнга, 43.9% нь хааяа ашигладаг гэсэн аж. Твиттер, сонинг 70 гаруй хувь нь огт ашигладаггүй байна (Эрдэнэчимэг О., Улаанбаатар хотод хийсэн захиалгат чанарын судалгааны тайлан 2024)

Хүснэгт 5. Иргэдийн мэдээ, мэдээлэл авдаг мэдээллийн эх сурвалж, нийгмийн сүлжээ

№	Мэдээллийн индрүүд	Байнга ашигладаг	Хааяа ашигладаг	Огт ашигладаггүй	Хариулаагүй
1	Facebook	74,2	15,2	9,1	1,5
2	Твиттер	10,6	13,6	72,7	3,0
3	Инстаграм	24,2	19,7	54,5	1,5
4	Телевизүүд	43,9	40,9	13,6	1,5
5	Сайтууд	27,3	43,9	25,8	3,0
6	Сонин	9,1	12,1	75,8	3,0
7	Бусад	7,6	15,2	42,4	34,8

Сошиал сүлжээний нэг болох фейсбүүк (Facebook) нь улс төр, нийгмийн сайн сайхан байдалд чиглэсэн олон асуудлаар асуудал дэвшүүлж, шүүмжлэл, хэлэлцүүлэг өрнүүлж бодит ажил хэрэг болж өргөн хүрээнд хэрэглэгдэж байна. Өөрөөр хэлбэл иргэд, олон түмний ая тухтай амьдрах орчин, аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой олон асуудлыг нийгмийн сүлжээ ашиглан хурдан шуурхай шийдвэрлэдэг суваг үндсэндээ бий болсон.

Мөн улс төрчид, төрийн байгууллагын авилга, албан тушаалын хэрэг, хүнд суртлыг газар дээрээс нь шууд сурвалжлан мэдээлдэг шинэ арга барилтай болсон. Энэ нийгмийн сүлжээг ашиглан нийгмийн хэв журам, хууль дүрэм зөрчсөн үйлдлүүдийг баримтжуулан бичлэг хийж, түүнийг нийтэд мэдээлж, хууль хяналтын байгууллагыг арга хэмжээ авахыг шаардах, бусдын төлөө сайн сайхан үйл хийсэн хүмүүсийг сайшаан дэмжиж алдаршуулах зэрэг олон ажлыг гүйцэтгэж нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлж байна. Үүний зэрэгцээ худал хуурмаг мэдээлэл, бусдын нэр төрд халдсан сөрөг үйлдэл ч дагалдан бий болсон.

Сошиал мэдээ, мэдээллийг иргэд, олон түмэн, иргэний нийгмийн байгууллагууд, худалдаа үйлчилгээний газрууд, хэрэглэхээс гадна төр засгийн байгууллагууд ч ашиглаж байна. Жишээ нь: Авилга, албан тушаалын хэргүүд болох ЖДҮ, Хөгжлийн банк, Нүүрсний хулгайн хэрэг, Боловсролын зээлийн сан, Эмийн сонсгол зэрэг хэргүүдийг шахалтанд оруулахад энэ нийгмийн сошиал сүлжээг ашигласан. Үүний үр дүнд Хөгжлийн банкнаас эрх мэдэл, албан тушаалаа ашиглан их хэмжээний зээл аваад эргэн төлөхгүй

байсан олон хүн богино хугацаанд өр төлбөрөө барагдуулсан. Мөн БЗС-аас албан тушаал, мэдээлэлд ойр байдлаа ашиглан зээл авсан олон эрхмүүд зээлээ төлж эхэлсэн ба цаашид төлж дуусгана гэдэгт нийгмийн сэтгэл зүй найдлага тавин хүлээж байна.

Сошиал сүлжээ түүн дотроо фейсбүүк (Facebook) нь Монголын нийгмийн маш идэвхитэй санаачилгатай ажилладаг ТББ-ын үүргийг сайн гүйцэтгэж байна гэж харж байна. Улс төрийн намуудын тухайд “сошаил” сүлжээг сонгуулийн болон бусад сурталчилгаанд идэвхтэй ашиглаж байгаа туршлага нилээн хэдэн жилийн өмнөөс бий болсон. Гадаадын улс орнуудад ч ийм туршлага олон байдаг. Тийм учраас энэ мэдээллийн гол суваг болох сүлжээг эрх баригчид зөв шийдэл олох, гаргах, хэрэгжүүлэхэд түшиж ажиллавал үр дүн гарах нь дамжиггүй. Харин энэ нийгмийн сүлжээгээр явж буй мэдээ мэдээлэл, санал шүүмжлэл бүрийг төр засгийн байгууллагууд заавал хэрэгжүүлэх шаардлагатай гэж бодохгүй байна. Төр, засаг амласан, төлөвлөсөн,, судалгаа нотолгоонд суурилсан, төрийн бодлогод тусгагдсан ажлаа заавал хэрэгжүүлэх шаардлагатай.

IV. Дүгнэлт

Аливаа нийгэмд болж буй үйл явцыг тухайн нийгмийн ард түмнээс салангид авч үзэх боломжгүй юм. Тийм учраас өнөөдөр Монголын нийгэмд болж буй улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явцад ард түмэн буюу нийгмийн сэтгэлзүй хэрхэн хандаж буйг социологийн судалгаа хийж дүн шинжилгээ хийв.

Өнөөгийн Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн байдлыг судалгаанд оролцогсдын 80.3% нь

“тааламжтай биш, хямралтай” гэж үзжээ. Энэ сөрөг хандлага юунаас болж байгааг судлахад Монголын нийгэмд хариуцлагын механизм, сахилга дэг журам алдагдаж, төрийн өндөр албан тушаалтнууд авилгал, хээл хахууль, албан тушаалын хэрэгт байнга холбогдож тэдэнд хариуцлага тооцдоггүй, байгалийн баялгийн тэгш бус хуваарилалтын үр дүнд нийгэмд баян хоосны ялгаа дээд цэгтээ хүрсэн, хууль хэрэгждэггүй, 2 стандарт бий болсон, төрийн болон намын хүний нөөцийн бодлого алдагдсан гэх мэт олон шалтгаануудыг дурьдаж болохоор байна.

Эдгээр бүх алдаа дутагдлын эх үүсвэр нь юу байна вэ? гэж өргөн утгаар судалж үзвээс: Монголын улс төрийн системийг бүрдүүлж байгаа улс төрийн намуудын бодлого, үйл ажиллагаанд шударга ёсны хэм хэмжээ алдагдсантай холбоотой гэж үзэх нигууртэй аж. Улс төрийн нам бол ардчиллын үндсэн институци. Улс төрийн нам анх үүссэн цагаасаа л төлөөллийн байгууллага байсан. Одоо ч энэ чанараа алдаагүй нийгмийн төлөөллийг хэрэгжүүлдэг байгууллага юм. Энэ байгууллагын нэр хүнд яагаад унав, ард түмэн яагаад тэдэнд итгэхээ болив гэдэг асуулт хамгийн түрүүнд гарах ёстой. Үүнд:

1. Аливаа ажлын эцсийн амжилт, үр дүн, үйл хэрэг зөвхөн тэр ажлыг гүйцэтгэж буй хувь хүнээс шалтгаалдаг. Төрийн бүх шатны албан тушаалд сонгуульд ялсан улс төрийн нам өөрийн төлөөллийн хүнээ байршуулдаг. Тэр төлөөллийн албанд хэн томилогдов, тэр хүн хэрхэн, яаж ажиллаж байгаагаас тухайн ажлын хувь заяа хамаарч байдаг. Ажилдаа эзний ёсоор хандаж ажиллавал олонхийн эрх ашигт нийцнэ, зөвхөн амин хувийн,

танил талын болон бүлэглэлийн явцуу эрх ашигт захирагдан ажиллавал нийтийн болоод ард түмний, улс эх орны эрх ашиг хохирно. Өөрөөр хэлбэл намын бодлого үйл ажиллагааг гишүүд, дэмжигсдийнхээ санал, дэмжлэгт тулгуурлан тэдний оролцоог хангаж ажиллах бус нийтийн эрх ашгаас урвуулж зөвхөн бүлэглэлийн явцуу эрх ашигт нийцүүлэн, намын удирдлагад ойр хэсгийг тойрсон улс төр, бизнесийн төлөөллийн зарчмаар явах болсны алдаа завхрал энд оршиж байна. Тийм учраас монголын улс төрийн намууд бодлого, үйл ажиллагааны шинэчлэл хийх цаг болсон.

2. Бидний туулж ирсэн 30 жилийн хугацаанд тулгарсан сорилт бэрхшээлийн гол асуудал болох улс төр, бизнесийн заагийг тогтоох, харилцан хамаарлыг хязгаарлах хууль эрх зүйн орчныг бий болгоход анхаарч ажиллах. Үүнд: олон жилийн туршлага хуримтлуулсан бусад улс орнуудын туршлагаас судлан манайд ямар зохицуулалт хийх боломж байгааг судлан хэрэгжүүлэх.

3. Ардчилсан нийгмийн хүний нөөцийн бодлогод элит, дунд, доод давхрагын хооронд байнгын шилжилт явагдаж байх ёстой. Энэ явцад нийгмийн дундаж давхрага тоо, чанарын хувьд бэхжиж, олон түмний дотроос илүү чадвартай, боловсролтой, авъяастай хэсэг нийгмийн шатаар дээш өгсөж байх зохицолтой. Хүмүүнлэг нийгмийн энэ үйл явц гажуудсанаас манайд хүн тойрсон хямрал бүх гажуудлын эх үүсвэр болж байна. Жишээ нь: Боловсролын зээлийн сан тойрсон үйл явдал үүний тусгал. Төрийн дээгүүр болон дунд тушаалын албан хаагчид, бизнес эрхлэгчид өөрсдийн мэдээлэлд ойр давуу

байдлаа ашиглан бусдын боломжийг хулгайлсан. Даргын болон мөнгөтэй эрхмүүдийн хүүхэд заавал өндөр хөгжилтэй оронд төсвөөс зээл аван суралцах зарчим байхгүй. Төсөв бол ард түмний, татвар төлөгчдийн баялаг. Тэр тусмаа эдийн засгийн эрх чөлөөнд хүрсэн нөхөд ч төрийн мөнгөнөөс зээл авч, түүнийгээ тэглүүлнэ гэдэг тухайн хувь хүний ёс суртахууны нэг үзүүлэлт. Мөн Хөгжлийн банк, ЖДҮ, БЗС, нүүрсний болон эмийн сонгогуудад нэр холбогдогсод явцуу ашиг сонирхлын зөрчилтэй, ухамсар, ёс зүй, төлөвшлийн хамгийн доод эрэмбийн төлөөллүүд гэж олон түмэн харж байна. Тийм учраас улс төрийн намын хүний нөөцийн бодлогыг чамбайруулж ардчилсан нийгмийн шалгарлаар явах боломжийг бий болгоход анхаарах.

4. Нийгмийн сэтгэл зүйг зөв чиглүүлэх, иргэдийн үнэт зүйл, үнэлэмж баримжааллыг зөв залж удирдахад хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээ /Facebook, Twitter, Instagram/, боловсрол, урлаг соёлын байгууллагуудыг төрөөс нэгдсэн бодлого чиглэлээр хангаж ажиллах хэрэгтэй байна. Хүн төрөлхтний хөгжлийн үнэт зүйл нь ёс суртахуун байдаг учир энэ чиглэлд хүч тавьж анхаарал хандуулах шаардлагатай. Хүүхэд залуучууд, иргэд олон түмэнд

эх оронч үзлийг төлөвшүүлэх, зөв хүн байх, зөв үйл, сайн сайханд тэмүүлэх итгэл үнэмшил бий болгоход чиглэсэн ТВ-ийн сурталчилгаа, контентууд бусад олон талт арга хэмжээнүүдийг тодорхой бодлого зорилго, төлөвлөгөөтэйгээр зохион байгуулан явуулах хэрэгтэй байна.

5. Өнөөдөр Монгол Улсад хяналт, хариуцлагын систем бүрэн алдагдсан. Хяналт, хариуцлага бол сайн засаглалын салшгүй нэгэн бүрдэл хэсгүүд билээ. Хуулийн хэрэгжилт дагасан тодорхой хяналт, хариуцлагын механизмгүйгээр нийгэм, эдийн засгийн үр нөлөөтэй хөгжил, авилгал, хээл хахуулиас ангижрах тухай ярих нь илүүц. Тиймээс бүх шатанд хяналт хариуцлагын тогтолцоог иж бүрэн төлөвшүүлэх шаардлага гарч байна. Хяналт хариуцлагыг бодитой хэрэгжүүлэх гол арга зам нь ухамсар, ёс зүй, төрийн бодлого, эрх зүйн зохицуулалт, ил тод мэдээлэл, сургалт, сурталчилгааны бүх арга механизмыг ил тод, үр нөлөөтэй хэрэгжүүлэх явдал юм.

Талархал: Тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд хамтран ажиллаж гүн туслалцаа үзүүлсэн Доктор С.Энхжин, Д.Билгээ, Г.Наранбаатар нарт талархал илэрхийлж цаашдын ажил, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Ашигласан материал

Эрдэнэчимэг О. 2022. “Хөрш орнуудын хөгжлийн бодлогын онцлог: ололт амжилт, сорилт бэрхшээл”. *Философи, эрх зүйн судлал* (Философийн хүрээлэн., ШУА “Тод бичиг” ХХК) (XXXVII): 100-116.

Эрдэнэчимэг О. 2024. Улаанбаатар хотод хийсэн захиалгат чанарын судалгааны тайлан. 33.

Эрдэнэчимэг О. 2023. Улаанбаатар хотод явуулсан судалгааны тайлан. 2023 оны

4 дүгээр сарын 16-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотод явуулсан судалгаа, Улаанбаатар, 32.

World Bank. 2023. “GDP - Mongolia.” <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.KD?locations=MN>

Transparency International. 2023. *Corruption Perceptions Index*. <https://www.transparency.org/en/cpi/2023>.

Хатанболд О, Ганцоож Б. 2023. “Авлигын эсрэг зохион байгуулж буй соён гэгээрүүлэх үйл ажиллагааны ач холбогдол: хэрэгцээ шаардлага, хүчин зүйлс.” *Философи эрх зүйн судлал* (Философийн хүрээлэн, ШУА, “Тод бичиг” ХХК (ХХХVIII): 60-79. <https://doi.org/105564/spej.v38il.3163>

Дэлхийн хөгжлөөрөө тэргүүлэгч зарим орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга, туршлага. УИХТГ. Харьцуулсан судалгаа СТ-13/239, 2014

GDP - Mongolia

<https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.KD?locations=MN>

Corruption Perceptions Index [https://www.](https://www.transparency.org/en/cpi/2023)

[transparency.org/en/cpi/2023](https://www.transparency.org/en/cpi/2023)

The Global Governance Index

<https://solability.com/the-global-sustainable-com/index/governance-capital>

<https://freedomhouse.org/countries/freedom-net-scores>

Түмэннаст Г. 2019. Изменения в социальном слое общества. Развитие, укрепление, проблемы и вызовы демократии в Монголии /1990-2019/ Улаанбаатар, Адмон принт

<https://freedomhouse.org/report/freedom-and-media/2019/media-freedom-downward-spiral>

Mancur Olson, “The rise and Decline of Nations; Economic growth, stagflation and social rigidities in New Haven”